



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах

Орон нутгийн ээлжит сонгуулийн урьдчилсан дүнгээр нэр дэвшигчдийн саналын тоо тэнцсэн сумдад дахин санал хураалт зохион байгуулахтай холбоотой нэмэлт зардалтай холбогдуулан улсын төсвөөс нэмэлт санхүүжилт олгоогүй бөгөөд өмнө олгосон санхүүжилтийн хэмнэлтээс холбогдох зардлуудад зарцуулсан байна.

АУДИТЫН КОД: ЗАА-2024/15-ШТА-НА



Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn
Аудитын менежер Х.Болдбаатар
Утас: 7046-3783, цахим хаяг: boldbaatarakh@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Жалбаа
Утас: 89330330, цахим хаяг: jalbaab@audit.gov.mn
Аудитор Д.Пүүжмаа
Утас: 99080797, Цахим хаяг: puujmaad@audit.gov.mn

Улиастай
2024 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу: Цахим хуудас www.open.audit.mn

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	3
ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ.....	3
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....	4
БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ БАТЛАГДСАН ТӨСВИЙН ХҮРЭЭНД ХУВААРИЛСАН БАЙНА...5-6	
БҮЛЭГ Б. ОРОН НУТГИЙН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧДИЙН САНАЛЫН ТОО ТЭНЦЭЖ ДАХИН САНАЛ ХУРААЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ ОЛГООГҮЙ БАЙНА.	7
ДҮГНЭЛТ.....	8
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	9



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/А 8

Улиастай

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, 18.10 дахь хэсэг, 2023 оны А/102 дугаар тушаалаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл нийцлийн аудитын газар болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэхийг шинжээч (Ч.Ундармаа)-д, нээлттэй аудит цахим хуудсаар нийтэд мэдээлэхийг аудитор (Г.Нармандах)-д даалгасугай.
3. Аудитын ажлын нотлох баримтыг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивт хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Б.Жалбаа)-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Болдбаатар)-т даалгасугай.



Д.БАТ-УНДРАА

№ 013010104

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
УИХ	Улсын Их Хурал
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МТБ	Мэдээлэл технологийн баг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Улсын төсвөөс хуваарилсан төсөв	
2	Аймаг сумын сонгуулийн хороодод хуваарилсан төсөв	
3	Улсын бүртгэлийн ерөнхий газраас хуваарилсан төсөв	
4	Цагдаагийн ерөнхий газраас хуваарилсан төсөв	

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	
Аудитын зорилт	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт арга зүй Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 8 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн аудитыг хийж гүйцэтгэсэн. Аймаг, нийслэл, сум, дүүргийн 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • <i>Орон нутгийн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх</i> • <i>Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх</i>
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймаг сумын сонгуулийн хороод, Улсын бүртгэлийн хэлтэс, аймгийн Цагдаагийн газрыг хамруулан зардлын гүйцэтгэлд аудитыг хийсэн.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг нийцлийн аудитын стандарт АДБОУС 100, 400,3000-4000, Монгол Улсын Төрийн аудитын “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудит MNS 6817-8:2020 стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашигласан.
Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежер Х.Болдбаатар нар хянан удирдаж, ахлах аудитор Б.Жалбаа, аудитор Д.Пүүжмаа нар 2024 оны 12 дугаар сарын 02-оос эхлэн 2024 оны 12 дугаар сарын 13-ний хооронд хийж гүйцэтгэлээ.
Хүндрэл бэрхшээл	Нэгдсэн удирдамжаар гүйцэтгэж буй аудиттай хугацааны хувьд давхардаж, зэрэгцээ аудитыг гүйцэтгэсэн.

БҮЛЭГ 1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд хуваарилсан байна.

Орон нутгийн ээлжит сонгуулийн хүрээнд аймаг, сумын 25 сонгуулийн хороо, 115 хэсгийн хороо байгуулагдаж 1194 хүний бүрэлдэхүүнтэй ажиллажээ.

Орон нутгийн ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс Аймгийн сонгуулийн хороонд 1,383.3 сая төгрөгийн 21 нэр төрлийн зардлыг хуваарилсан байна. Үүнд:

Хүснэгт 1. Улсын төсвөөс хуваарилсан төсөв

		/мян.төг/
д/д	Зардлын нэр	Батлагдсан төсөв
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	1,497.5
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	21,787.0
3	МТБ, даамлын сургалт	30,434.7
4	Бичиг хэрэг	18,400.0
5	Шуудан холбоо	22,350.0
6	Унааны зардал	94,710.0
7	Санал авах байр бэлтгэх	32,200.0
8	Сурталчилгаа	20,000.0
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1,300.0
10	Саналын хуудас, төхөөрөмж авах,хүргэх зардал	62,528.0
11	Томилолт зардал	21,946.8
12	Сүлжээний судалгаа хийх зардал	3,340.7
13	Саналын хуудас устгах зардал	550.0
14	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	12,040.0
15	Санал авах байрны түлшний зардал	12,900.0
16	Сурталчилгааны материал тараах унааны зардал	16,100.0
17	Шуурхай багийн зардал	3,200.0
18	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал	870,016.0
19	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	121,833.6
20	Тоног төхөөрөмжийн тохиргоо хийх	6,530.0
21	Болзошгүй зардал	9,660.0
ДҮН		1,383,324.3

Сумын сонгуулийн хороо, хэсгийн хороодод төсөв хуваарилахдаа байршил, алслагдсан байдал, хэсгийн хороодын тоо, ажиллах бүрэлдэхүүнд үндэслэн хуваарилалт хийсэн байна.

Хүснэгт 2. Аймаг сумын сонгуулийн хороодод хуваарилсан төсөв

		/мян.төг/	
д/д	Сонгуулийн хорооны нэр	Хуваарилсан төсөв	Ажиллах хүний тоо
1	Аймгийн сонгуулийн хороо	119,440.7	14
2	Алдархаан сумын сонгуулийн хороо	64,876.8	62
3	Асгат сумын сонгуулийн хороо	28,583.6	26
4	Баянтэс сумын сонгуулийн хороо	42,216.8	38
5	Баянхайрхан сумын сонгуулийн хороо	42,018.8	38
6	Дөрвөлжин сумын сонгуулийн хороо	52,415.2	48
7	Завханмандал сумын сонгуулийн хороо	42,185.2	38
8	Идэр сумын сонгуулийн хороо	41,796.0	38
9	Их-Уул сумын сонгуулийн хороо	60,826.0	56
10	Нөмрөг сумын сонгуулийн хороо	58,461.6	56
11	Отгон сумын сонгуулийн хороо	70,641.2	68
12	Сантмаргаз сумын сонгуулийн хороо	50,883.2	48
13	Сонгино сумын сонгуулийн хороо	51,023.6	46

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс олгосон санхүүжилтийн гүйцэтгэл

14	Тосонцэнгэл сумын сонгуулийн хороо	81,210.0	79
15	Тэлмэн сумын сонгуулийн хороо	60,447.6	56
16	Тэс сумын сонгуулийн хороо	47,262.4	44
17	Түдэвтэй сумын сонгуулийн хороо	52,661.2	48
18	Ургамал сумын сонгуулийн хороо	52,297.2	48
19	Улиастай сумын сонгуулийн хороо	68,412.4	69
20	Цагаанчулуут сумын сонгуулийн хороо	47,975.6	46
21	Цагаанхайрхан сумын сонгуулийн хороо	42,930.4	40
22	Цэцэн-Уул сумын сонгуулийн хороо	57,607.2	52
23	Шилүүстэй сумын сонгуулийн хороо	43,374.4	40
24	Эрдэнэхайрхан сумын сонгуулийн хороо	52,261.2	48
25	Яруу сумын сонгуулийн хороо	51,516.0	48
ДҮН		1,383,324.3	1194

Орон нутгийн ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой Улсын бүртгэлийн хэлтэст 107.4 сая төгрөгийг, аймгийн Цагдаагийн газарт 55.6 сая төгрөгийг улсын төсвөөс тус тус хуваарилсан байна.

Хүснэгт 3. Улсын бүртгэлийн ерөнхий газраас хуваарилсан төсөв

д/д	Зардлын нэр	Батлагдсан төсөв /мян.төг/
1	Сонгогчдын нэрийн жагсаалт хэсгийн хороодод хүргэх зардал	2,420.5
2	Бичиг хэрэг	4,394.5
3	Сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгслийг тээвэрлэх болон техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах шуурхай багийн зардал	9,836.0
4	Сургалтын зардал	24,225.0
5	Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол, унааны зардал	66,544.5
ДҮН		107,420.5

Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан улсын бүртгэлийн хэлтэс нь байгууллагын ажилтан 19, итгэмжлэгдсэн ажилтан 90, нийт 119 хүний бүрэлдэхүүнтэй ажиллажээ.

Хүснэгт 4. Цагдаагийн ерөнхий газраас хуваарилсан төсөв

д/д	Зардлын нэр	Баталсан төсөв /мян.төг/
1	Тээвэр шатахуун	3,000.0
2	Шуудан холбоо, интернет	15,320.0
3	Хоол хүнс	37,248.0
ДҮН		55,568.0

Аймгийн Цагдаагийн газрын алба хаагчид сонгуулийн санал хураалтын үеэр аюулгүй байдлыг хангаж хамгаалалтад үүрэг гүйцэтгэсэн байна.

Улсын бүртгэлийн хэлтэс болон аймгийн Цагдаагийн газар нь дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.

БҮЛЭГ 2. Орон нутгийн ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн саналын тоо тэнцэж дахин санал хураалт дахин санал хураалт зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс нэмэлт санхүүжилт олгоогүй байна.

Орон нутгийн ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой Аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан 1,383.3 сая төгрөгийн 91.4 хувь буюу 1,263.9 сая төгрөгийг сумдын сонгуулийн хороод сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд зарцуулжээ.

Улсын төсвөөс олгосон санхүүжилтийн 974.6 сая төгрөг буюу зардлын 70.5 хувь нь сонгууль зохион байгуулахад ажилласан алба хаагчдын цалин, урамшуулал, хоол, унааны зардал байна.

Улсын төсвөөс олгосон санхүүжилтийн сурталчилгааны, саналын хуудас, тоног төхөөрөмж авах, хүргэх, томилолт, тоног төхөөрөмжийн тохиргоо хийх, болзошгүй зардал зэрэгт нийт 6.5 сая төгрөгийн хэмнэлт үүссэнээс 0.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, бусад зардлыг саналын тоо тэнцсэн сумдад нэмэлт санал хураалт зохион байгуулах үйл ажиллагаанд зарцуулжээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн урьдчилсан дүнгээр Завхан аймгийн Асгат, Отгон, Цэцэн-уул, Завханмандал, Тосонцэнгэл сумдад нэр дэвшигчдийн саналын тоо тэнцэж нэмэлт саналт хураалт зохион байгуулсан байна.

Нэмэлт санал хураалт зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс нэмэлт санхүүжилт олгоогүй бөгөөд өмнө олгосон санхүүжилтийн хэмнэлтээс холбогдох зардлуудад зарцуулсан байна.

Орон нутгийн ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой өр, авлага үүсээгүй байна.

Дүгнэлт:

1. Сонгуулийн зардлын батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилтийг хуваарилан ажилласан байна.
2. Сонгуулийн урьдчилсан дүнгээр санал тэнцсэн 5 суманд сонгогчийн нэмэлт санал хураалт зохион байгуулсан байна.
3. Сонгуулийн зардлын хэмнэлтээс нэмэлт санал хураалт дахин сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд зарцуулжээ.
4. Улсын төсвөөс олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, өр авлагагүй ажилласан байна.
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлэн анхан шатны баримтыг бүрдүүлэн, архивын нэгж үүсгэсэн байна.
6. Сонгуулийн зардлын хэмнэлтийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

Байгууллагаас ирсэн санал:



**ЗАВХАН АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**

81090 Улиастай, Завхан аймаг

Утас: 7046-2454

И-мэйл: zavkhanelection@gmail.com

2024.12.11 № 75

танай _____ -ны № _____ т

Сонгуулийн хорооны дүгнэлтийн
хариу хүргүүлэх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн Аймаг, нийслэл, сум, дүүргийн ээлжит сонгууль
зохион байгуулахтай холбоотой дүгнэлттэй танилцаж, тухайн дүгнэлтэд санал хүсэлт
байхгүй болно.

ДАРГА  Т.РЭНЧИНВАНЖИЛ

